

**Ялгуусан хутагтын III дүр Лувсандамбадаржаагийн
товч намтрын тухай**

Торгуудын ОТГОНБАЯР*

Монгол Улс, Улаанбаатар,
ШУА-ийн Хэл зохиолын
хүрээлэнгийн Сурвалж бичиг,
төвөд судлалын салбар

Received: Aug 23, 2024

Revised: Sep 20, 2024

Accepted: Nov 06, 2024

Хураангуй: Засагт хан аймгийн Ялгуусан хутагтын III дүр Лувсандамбадаржаа (1757-1819) ламын намтрыг өөртэй нь нэг цаг үед амьдарч асан Гунтан гэгээн Гончогдамбийдонмэ (1762-1823) лам төвөд хэлээр зохиосон ажээ. Урьд өмнө нь уг III дүрийнх нь төвөд хэлээр бичигдсэн намтар мэдэгдээгүй боловч монгол бичгээр бичигдэж үлдсэн захиа, өргөх бичиг, Ялгуусан хутагтуудын уг эх зэрэг олон баримт мэдээ архивд хадгалагдан үлджээ. Бидэнд олдсон төвөд хэлээрх намтар нь урт барын 10 хуудас бөгөөд дотор нь тэмдэглэгдсэн мэдээ сэлт нь монгол бичгээр буй архивын баримтад ташаарч тэмдэглэгдсэн юм уу эсвэл кирилл үсэгт буулгахдаа андуурч буулгасан байж болохуйц зарим мэдээллийг залруулахад бага боловч нэмэр болохоор байна. Нэг цаг үед амьдарч байсан хүн зохиосон учраас Лувсандамбадаржаа ламын амьдрал, зохиол үйлсийг үнэн зөвөөр тодруулахад чухал хувь нэмэр болохуйц уг намтрын доторх мэдээллийн талаар өгүүлэх юм.

Түлхүүр үг: Засагт хан аймгийн Ялгуусан хутагт, Лувсандамбадаржаа, намтар зохиол

About a Brief Biography of Third Yalguusan Khutugtu Luvsandambadarjai

OTGONBAYAR Torguud

The Sector of the Textology and Tibetan Studies,
Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia

* © Т.Отгонбаяр 2024

Email: otgonbayar_t@mas.ac.mn

Abstract: *The biography of Luvsandambadarjai (1757-1819), the third Yalguusan khutugtu of Zasagt Khan province, was written by Gungtang Konchok Tenpai Dronme (1762-1823) in the Tibetan, who lived at the same time as him. In the past, there was no written biography of this third Yalguusan khutugtu in the Tibetan, but many documents such as letters, letters of appeal, and all Yalguusan khutugtu originals documents, written in Mongolian script have been preserved in the archive. The biography in Tibetan that we found is 11 pages in long block print, and the information written in it contributes to correcting some information that may have been mistakenly recorded in the Mongolian script archive documents or may have been mistakenly written down in Cyrillic. This article will briefly mention the information contained in the biography, which will be an important contribution to the accurate clarification of the life and writings of Lama Luvsandambadarjai because it was written by a person who lived at the same time.*

Key words: *Yalguusan Khutugtu of Zasagt Khan Province, Luvsandambadarjai, a brief biography*

1. Удиртгал

1.1. Судалгааны арга. Төвөдийн алдарт гүн ухаантан Гүнтан Гончогдамбийдонмэ лам Засагт хан аймгийн Ялгуусан хутагтын III дүр Лувсандамбадаржаа ламын товч намтрыг төвөд хэлээр бичиж үлдээснийг орчуулж, намтарт буй мэдээ сэлтийг урьд өмнө нь хийгдсэн бусад судалгааны үр дүнтэй харьцуулах, шинээр мэдэгдэж буй мэдээ сэлтийг задлан шинжлэх юм.

1.2. Судалгааны эх хэрэглэгдэхүүн. Гүнтан гэгээн Гончигдамбийдонмэ ламын зохиолыг Төвөдийн Лавран хийдэд 11 боть болгон хэвлүүлсний “ja” боть буюу тав дахь боть дотор “Шашны садан Ялгуусан эрдэнэ мэргэн бандида хутагт Лувсандамбадаржаагийн намтар Чандманийн толь хэмээх оршвой”¹²⁶ гэсэн гарчигтай, 1a-11b хуудас, урт барын судар буй юм. (Зураг 1)

2. Судалгааны хэсэг

Уг намтрын доторх агуулгыг зохиолч ном дотроо бүлэг болгож ангилж бичээгүй боловч бичсэн дарааллыг нь өөрчлөхгүйгээр урьд төрлүүдийн тухай, лагшин мэндэлсэн тухай, бага нас, ном эрдэмд суралцан шашин амьтны тусыг бүтээсэн нь гэсэн дөрвөн хэсэгт хуваан авч үзэж болохоор байна.

2.1. Урьд төрлүүдийн тухай. Намтрын эхэнд мөргөлийн шүлэг болон зохиогчийн тангаргийн шүлэг, сонсохыг сануулсан шүлгийг өгүүлээд Далай лам, Банчин богдууд Ялгуусан хутагтын урд төрлүүдэд залбирсан залбирал

¹²⁶ bstan pa'i rtsa lag yil gog san er ti ni mer gen paN+Ti ta hu thog thu blo bzang bstan pa dar rgyas kyi rnam thar nor bu'i me long zhes bya ba bzhugs so/

зохиосон ба Далай лам 7 төрөлд нь залбирсан залбирал, Банчин богд 13 төрөлд нь залбирсан залбирал зохиосон тухай өгүүлжээ. Урьд төрлүүдийг нь дурдан залбирсан төрөл үесийн залбирал *“Ялгуусан мэргэн бандида хутагт Лувсандамбадаржаан төрлийн дарааллын залбирал хэмээх оривой”* хэмээх залбирлыг VII Банчин богд зохиосон бөгөөд уг залбиралд:

1. Жансэм Нанвасаммичав (snang ba bsam gyis mi khyab/)
2. Шагжамидра (shAkya mi dra/)
3. Зунба Намдолдэ (btsun pa rnam grol sde/)
4. Пагчэн бандида (*phags chen paN+Ti ta/)
5. Намхайжанцан (nam mkha' rgyal mtshan/)
6. Ог Лэгвишэйрав (rngog legs pa'i shes rab/)
7. Жилвүва Чойжижанцан (spyil bu pa chos kyi rgyal mtshan/)
8. Сажа Ишдамбажанцан (sa skya ye shes bstan pa rgyal mtshan/)
9. Хордон Намхайбал (hor ston nam mkha' dpal/)
10. Чойжонжамц (chos skyong rgya mtsho/)
11. Лувсандамбийням (blo bzang bstan pa'i nyi ma/)
12. Лувсандамбажанцан (blo bzang bstan pa rgyal mtshan/)
13. Лувсандамбадаржаа (blo bzang bstan pa dar rgyas/) (bstan pa'i nyi ma/)

гэсэн 13 төрлийг нь дурдан залбирсан байдгаас Гүнтан Гончогдамбийдонмэ лам энэхүү намтартаа цөөн хэдэн дүрийнх нь талаар товч өгүүлсэн байна.

Лувсандамбадаржаа ламын өмнөх 12 дүрээс нь хамгийн эхний дүрийн талаар *“Анх Бурхан багшийн үед Нанвасамжмичав болж мэндэлсэн хэмээх нь бэлгэдэл төдий юм. Учир нь VI төрлийн Ог Лэгвийшэйрав болбоос Жовужуи Балдан Адиша эцэг хөвгүүнтэй олон төрлийн барилдлагатай бөгөөд бодисадын явдалд суралцсан ёс нь Гаадамбын номд байдаг мэт болой. Түүгээр үл барам Хү, Ог, Бром гурвыг язгуурын гурван бурхан лугаа найруулах цагт Ог нь Манзушир бурхны хувилгаан гэгддэг бөгөөд Даваадагва бээр Төвд орохуйн тайлбартаа: “Хутагт Манзушир бээр бодисадва болж түүнчлэн ажирсан Шагжстүв тэргүүтэн сэтгэл үүсгэхийг барихад оруулсан гэж гардаг билээ” гэж зарлигласан мэт бурхан бүгдийн эцэг болох болон хамаг бурхдын шавь нарын манлай болох ёсыг барьсан тэргүүтэн санаанд багтаагүй нууцын орон нь өгүүлэх, санахын хүрээнээс хэтэрсэн болой. Нийтийн ёсонд ч “Бурхны долоон ном төгссөн Гаадамбын эрдэнийн эрх”-ийн эзэн болсон бөгөөд удвис, адистидын дамжлагын уг нь үүнд тулах болой”* хэмээн анх Бурхан багшийн үед Нанвасамжмичав хэмээх болж төрөл авахаас ч өмнө төгс гэгээрсэн бөгөөд учир нь VI дүр болох Ог Лэгвийшэйравийг Манзушир бурхны хувилгаан гэж үздэг талаар дурджээ. Тийм биш байсан ч Ог Лэгвийшэйрав нь Гаадамбын дамжлагын эзэн юм хэмээжээ.

Мөн VIII дүрийнх нь талаар *“Иишжанцан нь ч айлдал, энэрэл, чадал, илт мэдэл, рид хувилгаан тэргүүтнийг эрхшээсэн ба Орчэн тэргүүтэн тэр үеийн*

Сажын ёсыг баригч бүгдээр оройн чимэг болгон өргөж зарлиг, мөр, үрийн увдисын эзэн болсон” гэж дурдсан бөгөөд энэ Ишжанцан (1359-1406) лам болбоос XIV зууны сүүл үед Төвөдөд мэндэлсэн, Сажа ёсны дээдэс лам юм.

Х дүрийн талаар *“Чойжонжамц нь Богд Зонхавын судар тарнийн номын ёсыг таалалдаа багтааж XVI Гандан ширээт болсон. Бурхан багшийн их дүрийг бүтээх тэргүүтэн асар их үйлсийг зохиосон. Маджүдийн найман их хөтөлбөр гэж алдаршсан нь ч энэ ламын зохиол бөгөөд Гэлүгвийн шашны эзэн болсон тэргүүтэн....”* хэмээн дурдсан уг лам нь Гэлүгвийн ёс буюу шар малгайтны ёсны хамгийн эрдэмтэй мэргэд ээлжлэн залардаг Гандан ширээтийн XVI ширээт лам болох Чойжонжамц (1473-1539) ажээ. Ялгуусан хутагтын Монголд тодорсон дүрүүдийн яг өмнөх дүр гэж үздэг энэ лам болбоос “1520 онд Төвөдийн нууц тарнийн Жүмэ дацангийн хамбын ширээнд залагдсан бөгөөд 1536 онд Гандан ширээтээр залагдаж байсан” (‘jam dbyangs shes rab/, 2018) ажээ.

Монголд мэндэлсэн I, II дүрийнх нь талаар *“Түүнээс цагийн эрхээр умар зүгийн Их Монгол орноо Богд Зонхавын шашныг дэлгэрүүлэх цаг болоход Нигүүлсэхүй, болгоол хослон орсноор амьтан бүхнийг нирвааны мөрд хөтлөхөд үйлс нь огторгуй сацуу түгсэн амьтны итгэл Дамбийням, түүний дараа дүр хамаг амьтныг энэрэгч их мөн чанарт Дамбийжанцан тэргүүтэн урд төрлүүдийн дэлгэрэнгүй намтрыг бусдаас мэдэж үйлдмүй зэ”* хэмээн дурдсан бөгөөд Засагт хан аймгийн Ялгуусан хутагтын анхдугаар дүр Дамбийням (165?-1721) лам Засагт хан аймгийн Хошууч мэргэний хошууны ноён Зодовын гэрт мэндэлж, нялх цагаас олон гайхамшигт шидийг үзүүлсэнд Засагт хан аймгийн зарим ноёд V Далай ламаас лавласнаар Бурхан багшийн үед Нанвасамжимичав гэдэг шашин ном дэлгэрүүлэгч хүн болж төрснөөсөө хойш Энэтхэг, Төвөдөд олон удаа хувилан төрсний хамгийн сүүлийн төрөл “XVI Гандан ширээт Лодойчойнзон-ы хойд дүр мөн болохыг баталсан” тухай судлаач З.Нинжбадгар, Х.Мэндсайхан (2021) нар судалгааны бүтээлдээ тодорхой тэмдэглэсэн байна.

2.2. Лагшин мэндэлсэн тухай. Гуравдугаар дүрийн Ялгуусан хутагтыг анх *Харуулын хөндий Оном Балжин мөрний захад өвгөн Цэвээнжав, эмгэн Гэмтэл хэмээх язгуур угсаа үгүй, эд баялгаар хоосрон машид зүдэрсэн хоёр буйг энэрлээр болгоож тэтгэн дэмжүүлэх хувьтнууд хэмээн таалж заларсан болой. Тэр нь ч XIII жарны буян хишиг зохилдсон гал үхэр жилд үр навч дэлгэрсэн цагт эмгэн нь аргал түүхээр явахад голын эргийн ёроолд эзэнгүй нялх хүү нэгэн байхыг харсан төдийд сэтгэлд зохистой их баясал болон хүүгээ хэмээх сэтгэл төрснөөр авсан хэмээн Гүнтан гэгээн өгүүлсэн энэ хэсгийн мэдээлэл нь монгол бичгээр архивд хадгалагдаж буй мэдээлэлтэй утга нь ижил боловч судлаачид Гуравдугаар дүрийн Ялгуусан хутагт Лувсандамбадаржаа Тэнгэрийн тэтгэсний 22 (1757)-р онд Ховдын Сономпэлжээ хэмээх голын хөвөөнд мэндэлжээ. Түүнийг хэрхэн мэндэлсэн тухай сурвалжуудад “Сономпэлжээ*

голын хөвөөнд ургасан улаан өнгийн цэцгүүдийн дунд нэг шар өнгөтэй цэцгийн навчин доторх тоорцгоос нэгэн хөвгүүн төрж, номын аялгуу адил дуу гаргаж (Нинжбадгар, Мэндсайхан, 2021: 16) хэмээн хуучин монгол бичгээс хөрвүүлэхдээ голын нэрийг бага зэрэг ташаарснаас гадна Онон Балж голын хөвөөнд лагшин мэндлээд дараа нь Ховд руу нүүсэн тухай мэдээлэл байгаагүй тул анхнаасаа л Ховдод мэндэлсэн гэж бичжээ.

2.3. Бага нас. Уг намтарт нас сүүдэр бага байх үеийнх нь тухай ч нэлээн дурдагдсан нь: *“7 настай байх үед нь эцэг эх хоёр нь хааны алба татвараар Ховд хэмээх газарт ирсэн. Урд хойдын гайхамшигтай олон шинж тэмдэгт дулдуйдаж эцэг эх хоёрт нь эргэлзээ төрсөн бөгөөд ажигч гярхай зарим нэг хүн ч энэ хүү жирийн нэгэн биш байна хэмээн ярьцаадаг байсны дээр нэг өдөр гэнэт “би Ялгуусан хутагт мөн” хэмээн тодорхой айлдсан”* хэмээн Ховдод лагшин мэндэлсэн бус харин 7 настайдаа эцэг эхийн хамтаар очсон тухай нь тодорхой өгүүлжээ. Мөн бага насандаа элдэв сонин содон шинж тэмдэг үзүүлж байсныг эргэн тойрных нь ажигч гярхай хүмүүс анзаарч эгэл жирийн хүүхэд биш гэлцдэг байжээ. Хожим нь өөрөө Ялгуусан хутагтын хойд дүр гэдгээ өгүүлжээ. Бага насандаа эгэл жирийн хүүхдүүдийн адилаар тоглож наадах боловч ялгаатай байдал нь *“нялхас тэр ч эгэл хүүхдүүдийн адил бус, тоглохдоо ч мод чулуу тэргүүтнийг бурхан, ном, суварга, багш, хийд гэх зэргээр нэрлэн өрж ном номлох, хийд барих тэргүүтнээр сайн шүтэн барилдлага ямагтыг зохиов”* хэмээснээр бусад хүүхдүүдийн адилаар айл гэр болж, адуу мал хариулж тоглох бус харин шашин номын зан үйл үйлдэн тоглож нааддаг байсныг нь өгүүлсэн байна.

Мөн бага насандаа үзүүлсэн сонин гайхамшигтай зарим үзэгдлүүдийг ч *“Төрөхдөө л байсан эрдмээрээ чухаг дээдийг тахиx, тогтоол тарни униихад хичээх, амьтныг энэрэх, илт мэдэл, чадал хүчин төгс байсан бөгөөд настай ээжийнх нь нүд өвдөхөд сангийн мод хүргэх дүр үзүүлсэн төдийд түргэн эдгэсэн. Нүдний цагаа гарсан зарим нэгэнд гараараа илсэн төдийд өвчин нь амарлих, зарим нэг хүнд таны өвчин тэдэн сар жилийн дараа эдгэнэ гэх зэргээр хэлэхэд яг тэр ёсоор нь болдог байв”* гэх зэргээр дурджээ.

Хутагтыг олж асрах үед эцэг эхийнх нь амьдрал нэлээн ядуухан байсан ч *“Түүнээс хойш эцэг эх хоёр нь ч урд лугаа адилгүйгээр амьжиргааны эд олдохдоо хялбар болж баясал дуриил төгөлдөр болов. Эмгэн нь шударга зантай, сайхан сэтгэлтэй нэгэн мөний дээр энэ дээдэс заларсны адистидаар чухаг дээдэд машид бишрэнгүй болж аль олдсоноо өглөгт өгөх нь ихэссэн бөгөөд өгөх юм байхгүй нь хамаагүй хол ойрын алжааж зүдэрсэн зочид гийчдийг хооллож ундлах тэргүүтэн сайн буянд хичээх болов”* хэмээн хутагтыг олж асарснаас хойш хоол унд, эд таваар олдохдоо хялбар болсон ба ээж нь угаас сайхан сэтгэлтэй нэгэн байсны дээр хутагт гэрт нь заларсны адистидаар улам

илүү сүсэгтэй болж орсон гарсан зочид гийчдийг харамгүй хооллож ундлах зэргээр өглөг буянд ихээхэн шамддаг болжээ.

Ард олны дунд Ялгуусан хутагтыг ус сүү ялгасан тул Ялгасан-Ялгуусан хутагт гэж нэрлэх болсон гэх аман яриа байдаг билээ. Үүнтэй төстэй нэгэн үйл явдал ч уг намтарт *“нэг удаа 13 хүн ирж эхээс нь идээ ундаа өгөхийг гуйсанд өгөх юм юу ч үгүй тул арга үгүй хэмээгээд тахилаас үлдсэн өчүүхэн будааг жижиг аягатай байгаа сүүндээ чанаж өгье гэхэд энэ яасан ч хүрэлцэхгүй тул хэрэггүй гэтэл би мэдэж байна хэмээгээд чанаж өгтөл бүгдээрээ цадсан ч үл дуусах тэргүүтэн рид хувилгааныг үзүүлж бүгдийг гайхируулав”* гэж дурдагдсан байна. Уг үйл явдал нь ус сүү хоёрыг ялгасан тухай өгүүлээгүй ч бурханд тахил өргөсөн жижиг цөгцтэй будааг жижиг аягатай сүүнд чанаж 13 хүнд өгсөнд тэд бүгдээр цадсан ч будаа нь үл дууссан талаар өгүүлжээ. Энэ үйл явдлын тухай яриа аман байдлаар дамжсаар утга нь алдагдаж ус сүү хоёрыг ялгасан тул Ялгасан хутагт гэх болсон гэж ард олны дунд ихээхэн яригдах болсон байна. Гэвч уг хутагтын алдрыг Ялгуусан гэж онцолсон нь монголоор Ялсан, санскритаар Зая буюу “Зая бандида” гэх цолын эхэнд буй үгтэй утга нэг болов уу гэж таамаглаж байна.

“12 настай байх үед хөгишин эцэг нь насан өөд болсон тул аль чадахаараа буянд хичээв... Түүний хойно бусдаас идээ ундаа тэргүүтэн гуйж хөгишин эхээ өөрийг нь төрүүлсэн эх мэт ачлан, өргөн хүндэлж зохиосон нь дээдсийн авир ёс юм... Идээ унд гуйхаар өөр тийш яваад буцах замд нь өлссөн нохой шувуу тааралдваас олсон бүхнээ өгөөд гар хоосон буцдаг байв. Нэг удаа өгөх юу ч үгүй явсан тул хүчээр бөөлжиж өгөв...” гэсэн хэсгүүдийг ажиглавал 12 сүүдэртэй байх үед аав нь нас барсан тул аль чадахаараа хойдын буяныг нь үйлдээд нас өндөр болсон ээжийгээ асарч тойглодог байсан тухай нь өгүүлжээ. Энэ хэсэг дэх хамгийн сонирхолтой өгүүлэмж нь өдөр бүр хоол унд эрж гадуур яваад олсон бага сага идээ ундаагаар ээжийгээ тэжээн амь зуудаг байсан ба заримдаа гэртээ харих замд нь өлссөн нохой шувуу таарвал тэднийг өрөвдөж олсон идээ ундаагаа өгөөд гэртээ хоосон буцдаг байжээ. Нэг удаа өгөх юмгүй хоосон явж байтал өлссөн нохой шувуу таарсныг өрөвдөж өөрийгөө хүчлэн бөөлжиж бөөлжсөө ч болтугай өгөөд санаа нь амарч харьсан эгэл хүний санаанд багташгүй энэрэн нигүүлсэх сэтгэлийг үүсгэн амьтныг хайрладаг байсан тухай нь өгүүлжээ.

2.4. Ном эрдэмд суралцан шашин амьтны тусыг бүтээсэн нь. Анх сахил санваар хүртэж ном эрдэмд шамдан суралцаж, шашин амьтны тусыг бүтээсэн талаар уг намтарт дурдагдсан хэсгүүдийг ажиглавал *Батад агч винайг баригч Лувсанринченгээс сахил авч машид гаран залгуулан гэгцэл сахил авч суртгаалын суурь арван хураангуй шагшаабадыг сайтар сахиж ном сонсох, дадуулахад ч шамдсанаар Эмгэний банди хэмээн сайн ёсны үлгэр жишээ нэгэн*

болов гэснээс үзвэл Ялгуусан хутагт бага наснаасаа ном эрдэмд шамдаж сайтар суралцсаны дээр сахил санваараа ч чандлан сахидаг байсан талаар;

Эд эдэлбэр юу ч үгүй тул учир шалтгааныг нь мэдэхгүй зарим нэгэн басамжлан доромжилж байв. Дээдэс энэ бээр би Ховдын хамба болно, Алдар гэх энэ газарт ч нэг хийд байгуулна хэмээн ирээдүйд болох зүйлийг илэрхий өгүүлсэн ч тэр үеийн эгэл олон инээдэм наадам болгож байв хэмээн нас сүүдэр бага байх үед нь зарим нэгэн хүн ядуу зүдүүгээр нь доромжлох, ирээдүйд болох үйл явдлыг зөгнөн хэлэхэд нь эгэл бодгаль биш гэдгийг мэдээгүй хүмүүс шоолон тоглоом тохуу хийдэг байсан ч нас бие гүйцсэн хойноо Алдархаан суманд сүм хийд байгуулж тэр нь өргөжсөөр “Завхан аймаг Алдархаан сум. Яруугийн хүрээ /Дашпунцаглин хийд/ Завхан аймгийн төв Улиастай хотоос баруун тийш 17 км-т Яруугийн голын эрэг Улиастай - Донойн нисэх буудлын замын урьд талд энэхүү Яруугийн хүрээ төвхнөж...” (Дашринчен) Яруугийн хүрээ Дашпунцаглин хийд болсон талаар;

36 настай байх үеийн усан хулгана жилд умар зүгийн амьтны итгэл богд Жэвзүндамба хутагтын өлмийд золгоход шашины садан хэмээн таалж таван давхар олбог, түшлэг лүгээ сэлтийг соёрхож “Эрдэнэ ялгуусан мэргэн бандида” хэмээх цол соёрхов хэмээн богд Жэвзүндамба хутагтад бараалхан мөргөхөд Жэвзүндамба хутагтын зүгээс олбог түшлэг тэргүүтэн эд, Эрдэнэ ялгуусан мэргэн бандида цолыг анх соёрхсон талаар;

Энэ үеийн Ховдын цэргийн тэргүүн амбан Цэвэг хэмээх бээр энэ дээдсийн үйлс зохионгуйг үзэж биширэл төрсний дээр Түгээмэл амаржуулагч хийдийн хамба Наро банчэн хутагт жанч халсны орлогч хэрэгтэй болсон тул энэ дээдэс шашинд ихээхэн тустай хийгээд орон нутгийн хамаг төрөлхтөн бүгд машид биширдэг тул Түгээмэл амаржуулагч хийдийн хамбад тушааж болох уу? хэмээн бичиг өргөсөнд баясан зарлиг буулгаж 46 насандаа усан нохой жилийн намрын тэргүүн сарын шинийн нэгэнд Түгээмэл амаржуулагч хийдийн хамба болов хэмээн Түгээмэл амаржуулагч хийдийн хамба байсан Наро банчэн хутагтыг жанч халсны дараа орлон хамба болсон тухай өгүүлжээ. Энэ тухай өөр сурвалжуудад ч дурдагдаж үлдсэнийг судлаачид бүтээлдээ “Түүнийг Ховдын Түгээмэл амаржуулагч сүмд сууж буй тухай засаг Үржинжавын бичигт ‘...миний хошууны Ялгуусан хутагт хэмээх нэгэн ламыг Ховдын Хэбэй амбаны газраас айлтгаад Наро банчин хутагтын төлөөнөө Ховдын сүм захируулан¹²⁷...’ гэжээ” (Нинжбадгар, Мэндсайхан, 2021: 17) гэх зэргээр эш татан дурджээ.

Нэг удаа Хар шаарын торгуудын ноён Данжинванжилын нутагт хар бодоо өвчин их дэлгэрснээр олон амьтан зовж буйг аврахаар хааны алтан зарлигаар заларч олон зуун амьтныг цагийн аюулаас авран тус амгалангийн

¹²⁷ МУУТА. ТБА. Х-9. Д-3. ХН-1470. Н-16

мөрт байгуулав. Тус тусдаа алт, мөнгө, торго, адуу мал гээд буй бүгдээрээ тахил өргөв. Гэвч Ялж төгс нөгчсөн бээр “үйлийн тийн боловсрол нь хамаарахгүй болой” хэмээн үйлийн үр нь нэгэнт боловсорсон болбоос бурхан ч аврах аргагүй хэмээсэн зарлигласанчлан тэр ноёны урьдын хаягдал барагдсан үйлийг буцааж болохгүйг болгоогоод үүний амийг би ч аварч үл чадах буй хэмээн зарлиглав. Тэрээр өргөл өргөсөн нугуудыг ч авалгүй буцаагаад өөрөө буцаж залрах үед тэр ноён ч нас нөгчсөнд бүгдээр ихэд сэтгэл итгэмжлэв гэсэн энэ хэсэгт нэр нь дурдагдсан Хар шаарын торгуудын ноён Данжинванжилын тухай “Илтгэл шастир”-т “Хошуучийн хан хэргэмийг, дүү Данзанванжилаар залгамжлуулав. Гуравдугаар удаа залгамжилсан Данзанванжил. Хошуучийн дүү. Сайшаалт ерөөлтийн арван нэгдүгээр он, засаг, Зоригт хан залгаж, чуулганы дарга тавив. Арван гуравдугаар (1808) онд үгүй болов.” (Сүхбаатар, 2020: 53) гэж дурдагдсанаас анзаарвал Ялгуусан хутагт 1808 онд 51 сүүдэртэйдээ хааны зарлигаар Хар шаарын торгуудын нутагт морилж тэнд гарсан тахал өвчнийг амарлиулж байжээ. Тэр үед өвдөж зовсон олон амьтныг аварч өвчин тахал намжсанд нутгийн ард олны зүгээс өглөг болгон өргөсөн эдүүдийг ч буцаан эздэд нь өргөжээ. Харин нутгийн ноёныг өвчнөөс нь салгаж чадаагүй ба нэгэнт үйлийн үр нь боловсорсон тул түүнийг бурхан ч аварч чадахгүй хэмээн айлдаад өөрийн нутагтаа эргэн морилсны дараа ноён нас баржээ.

Ялгуусан хутагтын энэхүү товч намтрын дотор дээрх мэтээр шашин амьтны тусыг бүтээсэн олон үйл явдлыг тэмдэглэн өгүүлжээ. Судрын төгсгөлийн үгэнд Гунтан гэгээнд хэн дуртган сануулж, хаана зохиосон зэргийг тодорхой дурджээ. (Зураг 2) Энэхүү намтраас өгүүлэлд дурдагдаагүй хэсгүүд ч олон буй тул Төвөд судлал сэтгүүлийн XIII дугаарын орчуулга буланд төвөд эхийг нь шинээр шивж монгол орчуулгын хамт хэвлэсэн тул тэндээс бүтнээр нь уншиж болох юм.

3. Дүгнэлт

Уг намтар хэдий бага хэмжээний боловч Ялгуусан хутагтын III дүрийн намтрын талаар судалгаанд тодорхой хэмжээгээр нэмэр болохоор бүтээл ажээ. Урьд нь уг дүрийнх нь талаар судалгааны бүтээлүүдэд дурдагдсан мэдээнүүдээс зөрүүтэй болон нэмж баяжуулахуйц мэдээллүүд олон байгааг харвал судалгааны эргэлтэд ороогүй шинэ сурвалж байсныг нь илтгэнэ.


Намтар дотор хүний санаанд оромгүй хэтэрхий хийсвэрлэг гэж болохуйц хэсгүүд байгаа боловч Ялгуусан хутагтын энэ дүртэй нэгэн цаг үед амьдарч байсан хүн бичсэний хувьд төрсөн газар, нүүж шилжсэн газар, хэрхэн ном эрдэмд суралцсан, шашин амьтны тусыг хэрхэн бүтээж байсан, хэзээ хаана цол хэргэм хүртсэн гэх зэргийг тодорхой гаргаж бичжээ. Мөн намтрыг бүтэн уншваас Яруугийн хүрээ Дашпунцаглин хийдийг анх байгуулахдаа ямар хэлбэр хэмжээтэй, хэдэн дугантай, ямар ямар нандин шүтээнтэй, хэр хэмжээний өртөг

зардлаар барьж байгуулж байсныг мэдэх зэрэг олон сонирхолтой мэдээ баримтуудыг агуулжээ.


Ном зүй

- Лувсанринчен.** (1959). *Төвөд, Монгол дохионы бичиг Нэр, үг, утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч зул оршвой*. Дурсгалт бичгийн чуулган цуврал. Дугаар- 5, 6. Редактор: Б.Ринчен (Luvsanrinchen, *Tövöd, Mongol dohiony bichig Ner, üg, utga gurvyg todruulan haranhuig arilgagch zul orshvoi*. [Tibetan-Mongolian Dictionary] Corpus Scriptorum Mongolorum. Tomus-5, 6. Editor: B.Rinchen., Ulaanbaatar, 1959]
- Нинжбадгар, З., Мэндсайхан, Х.** (эмх), (2021). *Засагт хан аймгийн Ялгуусан хутагтууд*, Улаанбаатар: Адмон принт ХХК. (Ninbadgar, Z., Mendsaihan, H. *Zasagt han aimgiin Yalguusan Hutagtuud* (All Yalguusan Khutugtu of Zasagt khan Province] Ulaanbaatar, Admon print: 2021.)
- Сүхбаатар, На.** (эрхлэн хэвлүүлсэн). (2020). *Зарлигаар тогтоосон залгаж зохиосон гадаад мужийн Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир*. Улаанбаатар: Соёмбо принт (Sukhbaatar, Na., *Zarligaar togtooson zalgaj zohioson gadaad mujiin Mongol, Khoton aimgiin van güngüüdiin iltgel shastir*. [Annals of the speeches] Ulaanbaatar: Soyombo printing Co., Ltd]
- Тэрбиш, Л., Чулуун-Эрдэнэ, Т.** (2011). *Төвөд-Монгол их толь бичиг*. (Terbish, L., Chuluun-Erdene, T. *Tövd-Mongol ikh toli bichig*. [Big Tibetan-Mongolian Dictionary.] National Museum of Ethnology Osaka]
- Цахим холбоос:**
- Дашринчен, Д.** *Яруугийн хүрээ - Аман түүх*. (Dashrinchen, D. *Yaruugiin khüree - Aman tüüh* (Monastery of Yaruu - Oral history.) Retrieved from <https://www.mongoliantemples.org/mn/component/domm/486?view=oldtemplemn>]
- dkon mchog bstan pa'i sgron me/.** *mer gen paN+Di ta blo bzang bstan pa dar rgyas kyi rnam thar nor bu'i me long* / https://library.bdrc.io/show/bdr:MW1KG9408_DB1434 Retrieved from library.bdrc.io
- 'jam dbyangs shes rab/.** (2018). *dga' ldan khri thog bcu drug pa rgya ra chos skyong rgya mtsho/*. Retrieved from <https://www.tb1025.cn/lg/muna/saichi/2016-03-18/501.html>.
- bstan pa'i nyi ma/.** *er te ni i la khug san mer khan paN+Di ta khu thog thu blo bzang bstan pa dar rgyas kyi skyes rabs rnam thar.* vol-5. https://library.bdrc.io/show/bdr:MW6205?part=bdr:MW6205_181725. Retrieved from library.bdrc.io
- thub bstan bsam grub/.** (2013). *sgom sde tshig mdzod chen mo/* Retrieved from <https://www.serajeyrigzodchenmo.org/da-rigpa/tibet/tsig-zod/item/549-rndtt205002>]


Хавсралт



Зураг 1. “Шашны садан Ялгуусан эрдэнэ мэргэн бандида хутагт Лувсандамбадаржаагийн намтар Чандманийн толь хэмээх оршвой” судрын нүүр хуудас. Цахим эх сурвалж: MW1KG9408_DB1434 Retrieved from library.bdrc.io



Зураг 2. “Шашны садан Ялгуусан эрдэнэ мэргэн бандида хутагт Лувсандамбадаржаагийн намтар Чандманийн толь хэмээх оршвой” судрын төгсгөлийн үг: хэмээн умар зүгийн шашин амьтны тус амгалангийн дээд садан болсон Ялгуусан Эрдэнэ мэргэн бандида хутагт Лувсандамбадаржаагийн намтар Чандманийн эрх хэмээх үүнийг шашныг гийгүүлэгч Баари хувилгаан эрдэнэ хамба Агванчэнээ тэргүүтэн Түрчэн хийд Тойсамдаржаалингийн лам хар олноос урьд хожид дахин дахин сануулсан ба цорж Лувсангончоог эзний тухайлан тушаалаар ирээд дуртгасанчлан тойн Гончогдамбийдонмэ бээр Ялгуусны эшээр эзлэгдсэн номын их хүрээ номлол бүтээлийн шашин гарахын орон цогт төгс Дашичид найруулсны бичээч нь аграмба Радна-Ананд бээр үйлдсэн үүгээр цаг бүхэнд хотол чуулган өлзий хутаг ориших болтугай. Цахим эх сурвалж: MW1KG9408_DB1434 Retrieved from library.bdrc.io



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.